

Golomt Capital®

БОНДЫН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ



2025.04.02



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БОНД

Нэр	Дуусах хугацаа	Купон	Өгөөж
Номад	2026.04.07	5.125%	5.90%
Монгол 27	2027.07.27	3.50%	6.40%
Хүннү	2028.01.19	8.65%	6.35%
Монгол 29	2029.06.05	7.875%	6.43%
Монгол 30	2030.02.25	6.625%	6.70%
Монгол 31	2031.07.07	4.45%	6.72%

Эх сурвалж: Bloomberg

Монгол Улсын Засгийн газар бондуудын өгөөж 5.90%-6.72% хооронд хэлбэлзэж байна.



КОМПАНИЙН БОНД (АМ.ДОЛЛАР)

Нэр	Дуусах хугацаа	Купон	Өгөөж
Голомт Банк (GLMT)	2027.05.20	11.00%	8.62%
МИК (MIK)	2027.01.18	11.50%	9.75%
MMC	2026.09.13	12.50%	6.85%
DBM	2026.03.07	11.00%	6.95%

Эх сурвалж: Bloomberg

Компанийн ам.долларын бондуудын өгөөж 6.95%-8.20%-ийн түвшинд хэлбэлзэж, эрсдэлийг давж өндөр өгөөж хайж буй хөрөнгө оруулагчдын сонирхлыг татаж байна. Голомт Банк олон улсын зах зээлд жилийн 11%-ийн хүүтэй, 2027.05.20-нд хаагдах 300 сая ам.долларын бондыг амжилттай гаргасан бөгөөд хоёрдогч зах зээлийн арилжаагаар худалдан авах боломжтой хэвээр байна.

Голомт Капитал компанийн хамт олон таныг цаашид ч бондын зах зээлд хөтлөн судалгаа, мэдээлэл, зөвлөгөө, шинэ бондод хөрөнгө оруулах боломжоор хангахаас гадна өндөр өгөөж хүртэхэд тань туслах болно.

Бүртгүүлэх:

<https://golomtcapital.com/forms/gc-academy2025>

“БОНД”-ЫН

АНГИЙН БҮРТГЭЛ ЭХЭЛЛЭЭ



АМ.ДОЛЛАРЫН БОНДЫН СУУРЬ МЭДЭЭЛЛҮҮД

АНУ-ын бондын өгөөж буурав.

АНУ-ын бондын өгөөж буурч, 4.533 хүрсэн ч дахин сэргэн 4.584%-д хүрлээ. АНУ-ын бондын өгөөж буурсан учир нь үйлдвэрлэлийн салбар агшиж, хөдөлмөрийн зах зээл суларч, Трампын тарифын төлөвлөгөө хөрөнгө оруулагчдын болгоомжлолыг нэмэгдүүлжээ. 10 жилийн бондын өгөөж 4.154%-д хүрч унасан, Goldman Sachs 2025 оны таамаглалаа 4% болгон бууруулав.


АНУ-ын Засгийн газрын бондын өгөөж нь эдийн засгийн нөхцөл байдал, инфляц, төв банкны бодлого зэрэг олон хүчин зүйлээс хамааран байнга өөрчлөгдөж байдаг.

График 1. АНУ-ын урт хугацаат бондын өгөөж



Эх сурвалж: Tradingview

График 2. АНУ-ын Бодлогын хүү



АНУ-ЫН ХНС БОДЛОГЫН ХҮҮГ 4.5%-Д ХЭВЭЭР НЬ ХАДГАЛЛАА. Гэхдээ энэ онд хүүг бууруулах төлөвтэй байна. Тодруулбал, 2025 онд 0.5 хувиар хүүг бууруулах боломжтой гэж үзэж байгаа тул 2 удаагийн шийдвэрээр нийт 0.25 хувиар буурах төлөвтэй байна.

Мөн мөнгөний хатуу бодлогыг бага багаар зөөлрүүлж, бэлэн мөнгөний эргэлтийг сайжруулснаар зах зээлд эерэг дохио өгнө гэж үзэж байна.

Эх сурвалж: JPMorgan.com



БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Биржийн бус зах зээлийн долоо хоногийн арилжааны тойм

Дотоодын биржийн бус зах зээлд нийт 111,840 ширхэг үнэт цаас арилжаалагдаж, 46.06 тэрбум төгрөг, 88,165.99 ам.долларын үнийн дүнтэйгээр арилжаа хийгдлээ.

- Анхдагч зах зээлд 20,016 ширхэг үнэт цаас 20.02 тэрбум төгрөгөөр арилжаалагдсан.
- Хоёрдогч зах зээлд 91,824 ширхэг үнэт цаас 26.05 тэрбум төгрөг, мөн 44 ширхэг үнэт цаас 88,165.99 ам.доллараар арилжаалагдав.

2024 онд 1.6 их наяд төгрөгийн үнэт цаас зах зээлд арилжаалагдсан нь өмнөх оноос 2 дахин өссөн үзүүлэлт юм. Нийт арилжааны 57.8 хувийг компанийн бонд, 22.7 хувийг хувьцаа, 6.5 хувийг хөрөнгө оруулалтын сан (ХОС)-гийн нэгж эрх, 13.0 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ)-ны арилжаа тус тус эзэлж байна.


Эх сурвалж: Otc.mn

Биржийн бус зах зээлийн бондын өгөөжийн муруй

Бондын өгөөжийн муруй нь зах зээлд гарч буй бондуудын хугацаа болон өгөөжийн хамаарлыг нь илтгэдэг. Өгөөжийн муруйг дараах зорилгоор ашиглах боломжтой. Үүнд:

- Үнэт цаасны өгөөжийн хувь үнэт цаасны хугацаанаас хамааран хэрхэн ялгаатай тогтож байгааг мэдэх
- Шинээр гаргах үнэт цаасны үнэ ханш, өгөөжийг тогтоох жишиг хувь болох
- Бусад бондын өгөөжтэй харьцуулан шийдвэр гаргах боломжийг олгодог юм.

График 2. Бондын өгөөжийн муруй (2024.10-р сард бодлогын хүү өөрчлөгдсөнөөс хойш)



АНХДАГЧ зах зээл-Төгрөг

Бондын нэр	Төрөл	Купон	Хүү төлөлт	Хэмжээ	Салбар	Хугацаа	Захиалга эхлэх
БОНД-1	Хаалттай	18.00%	Хагас жилд	20.0 тэрбум	Эрчим хүч	24 сар	2025/03/11

АНХДАГЧ зах зээл-Ам.доллар

Бондын нэр	Төрөл	Купон	Хүү төлөлт	Хэмжээ	Салбар	Хугацаа	Захиалга эхлэх
БОНД-2	Хаалттай	11.00%	Улирал бүр	16.4\$	Уул уурхай	12 сар	Эхэлсэн